



ПРЕМИУМ НЭКСУС ХК-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2026 оны 03 сарын 26 өдөр

Дугаар 7

Улаанбаатар хот

Газар эзэмших эрх шилжүүлж авах
сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дох заалт, Премиум Нэксус ХК ("Компани")-ийн Дүрмийн 9.4.18 дахь заалт болон Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хорооны дүгнэлтийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн зэргэлдээ компани болох Юу Эм Эс ХХК-ийн нэр дээрх Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг 11-р хороо, Ургах наран хаягт байрлах, нэгж талбарын 1333114195 дугаартай, улсын бүртгэлийн Э-2204046147 дугаартай, үйлдвэрлэлийн барилга, байгууламж, бусад газар зориулалт бүхий 51,723 м.кв газрын эзэмших эрхийг нийт 1,361,000,000 (нэг тэрбум гурван зуун жаран нэгэн сая) төгрөгөөр Компанийн нэр дээр шилжүүлж авах сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрсүгэй.
2. Юу Эм Эс ХХК-тай Газар эзэмших эрх шилжүүлэх гэрээ болон бусад холбогдох гэрээг байгуулах, баримт бичгийг үйлдэх, газрыг Компанийн нэр дээр бүртгүүлэхтэй холбоотой шаардлагатай арга хэмжээг авч ажиллах эрхийг Гүйцэтгэх захирал (Г.Чинзориг)-д олгосугай.


(Гарын үсгийн хуудас дагалдана)

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ДАРГА (ХАРААТ БУС):



ГАРИ БИОНДО

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД:




А.ГАНХУЯГ



А.ГАНБОЛД



Г.БАТ-ЭРДЭНЭ




Ч.МӨНХЧИМЭГ




Г.ЧИНЗОРИГ



Б.БАТ-ЭРДЭНЭ



Ө.ЭРДЭНЭЧИМЭГ



В.ГАНЗОРИГ